

Төрийн нууц ба бодит байдал

"Чөлөөт хэвлэл гэж чөлөөт ард иргэдийг хэлнэ" гэж Чөлөөт хэвлэлийн Хартид томъёолсон байдаг нь тохиолдлын хэрэг бус билээ. Үүний цаана иргэдийн мэдээлэл олж авах боломжоос хэвлэл чөлөөтэй эсэх асуудал хамаарна гэсэн энгийн боловч хөдлөшгүй логик агуулагддаг. Энэ логикийг ардчилал, шударга ёс, хэвлэлийн эрх чөлөөг эрхэмлэгч улс орон бүр үйл ажиллагаандаа мөрдлөг болгодог. Үндсэн хууль болоод бусад хууль тогтоомждоо энэ үзэл баримтлалыг хөхүүлэн дэмжсэн заалтууд оруулж, хүн төрөлхтний олон мянган жилийн хөгжил, дэвшлийн хамгийн үнэт ололт болсон ардчиллыг түүгээрээ дамжуулан хамгаалж байдаг.

Тэгвэл Монгол оронд байдал ямар байна вэ? Бид хүний эрхийг дээдэлж чадаж байна уу? Бид иргэдээ мэдээллээр чөлөөтэй хангаж чадаж байна уу? Бид чөлөөт хэвлэлийн эзэн чөлөөт иргэдтэй байж чадаж байна уу? гэсэн асуулт зүй ёсоор тавигдаж байна.

Нөгөө талаар Монгол гэдэг дэлхийд данстай туурга тусгаар улсын эрх ашиг, үндэсний аюулгүй байдал улам бүр даяаршилагдаж, нээлттэй болж буй дэлхий ертөнцийн ашиг сонирхолын харилцан эерэгшил, эсрэгцлийн торгон хил хаана байна вэ? Монголын төр мэдээлэлжсэн ертөнцийн өнгө төрх, хөгжлийн чиг хандлагыг хэр соргог мэдэрч байна вэ? Далан жил монголын төрд ноёрхож бүхнийг хүчирхийллийн аргаар шийддэг, энэ аргаа зөвтгөхийн тулд, нууж хаахын тулд аливаа мэдээллийг төрийн нууц гэдэг хар авдарт хав дарчихаад салхи үзүүлдэггүй байсан гаж зуршлын үндэс язгуур нь таслагдсан уу? Үр дагавар нь байна уу, байвал ямар хэлбэрээр илэрч байна вэ? гэсэн асуулт ч зүй ёсоор тавигдаж байна.

Манай судалгааны баг эдгээр асуултын хариуг эрж, бодит байдлын дүр зургийг тодруулахын тулд Төрийн Нууцын Тухай Монгол Улсын Хуульд тусгайлан заасан болон оруулаагүй янз бүрийн мэдээллийг олж авах боломжийг тандан судаллаа.

Судалгааны явцад олж цуглуулсан баримт материалд түшиглэн хийсэн дүгнэлтээ хэлэхээс өмнө ямар ямар байгууллагад хандан ямар мэдээлэл олж авах оролдлого хийсэн, тэдгээр оролдлогын үр дүн ямар байсан талаар товч тоймлоё.

Бид УИХ, Засгийн газар, Батлан хамгаалах яам, улсын аюулаас хамгаалах газар, шүүх, прокурорын газар, Гадаад хэргийн яам, Үндэсний аудитын газар, Улсын мэргэжлийн хяналтын газар, Байгаль орчны яам зэрэг газруудад хандан янз бүрийн цаг үед, улс хооронд байгуулсан гэрээ хэлэлцээр, өндөр дээд түвшний албан тушаалтнуудын уулзалтын тэмдэглэл, эх орны дайны үеийн төлөвлөгөө, цаазаар авах ялтай холбоотой асуудлууд, мэргэжлийн байгууллагуудын хяналт шалгалтын тайлан зэрэг өргөн хүрээтэй асуудлаар мэдээлэл олж авах оролдлого хийлээ. Ингэхдээ оюутан, багш, судлаач, өдөр тутмын сонины сэтгүүлч зэрэг хүмүүсийг татан оруулж тандалт хийлгэлээ.

Бид Зэвсэгт хүчний төв архивт хандан 1939-1945 оны дайны үеийн төлөвлөгөөтэй танилцаж болох эсэх талаар лавлахад “Улсын нууцад хамаарах тул болохгүй” гэсэн хариулт өглөө.

Монгол улсаас ОХУ-д төлөх Их өрийг эцэслэн шийдвэрлэсэн гэрээ, протоколтой танилцах хүсэлт маань Засгийн газар, Гадаад хэргийн яамны хооронд харилцан бөмбөг өшиглөлтөөр өндөрлөв.

Улсын мэргэжлийн хяналтын байгууллагад хандсан хүн амын хүнсний аюулгүй байдалд хийсэн шалгалтын дүнтэй танилцах хүсэлт ч “улсын нууц” гэсэн тайлбартайгаар буцав.

Гадаад хэргийн яам, АНУ-ын төрийн нарийн бичгийн дарга Уэльсийн айлчлалын тухай баримтыг дуртайяа үзүүлж, нууцын зэрэглэлгүй л бол ямар ч материалыг төлбөрөө төлөөд үзэж болно гэсэн хариулт өглөө. Энэ мэтчилэнгээр тандалтын эцсийн үр дүн харицан адилгүй байсан бөгөөд бүхэлд нь авч үзвэл дараах дүгнэлтийг хийж болохоор байна.

1. Иргэдийн мэдээлэл олж авах эрхэд “Төрийн нууц”, “Улсын нууц” гэсэн үгээр хаалт халхавч тавих явдал түгээмэл байна. 1995 онд батлагдсан

Төрийн нууцын тухай хууль нь батлагдсан өдрөөсөө хойш үйлчилнэ гэж үзвэл өмнөх үеийн нууцлалд хамруулсан материалуудыг хууль эрх зүйн ямар актаар зохицуулж буй нь тодорхойгүй байна гэж хэлж болох юм. 2004 оны хуульчилсан Төрийн нууцын жагсаалтыг мөрдлөгө болговол нууцлах хугацаа нь хэтэрсэн материалуудтай ч иргэд танилцах боломж хомс байна.

2. Мэдээлэл нээлттэй мэт боловч иргэдэд үзүүлж байсан практик байхгүй гэсэн хачирхалтай тайлбартай тулгарах явдал түгээмэл байна. Өөрөөр хэлбэл "уг нь хуулиар бол нууц биш, гэхдээ иргэн хүн тийм төрлийн мэдээлэлтэй танилцаж байсан тохиолдол байхгүй" гэсэн хариуг хэн нэгэн түшмэл өгөөд далаа хавчин эелдэгээр инээмсэглэх үзэгдэл хэвших хандлагатай байна.

3. "Уучлаарай бидэнд нуух юм юу ч байхгүй. Бүх зүйлийг интернэтэд тавчихсан байгаа. Ороод үз" гэсэн хариу өгдөг, хаягаар нь ороод үзэхээр хүссэн хэмжээний мэдээллээ олж үзэх боломжгүй байх нь ч ажиглагдаж байна.

4. Мэдээллийг иргэдэд төлбөртэйгээр өгөх явдал нь зарим тохиолдолд Төрийн нууцлалтай хамааралгүй бичиг баримттай танилцахад нь хүндрэл учруулж байна. Тухайлбал прокурорын байгууллагад буй нэгэн сэтгүүлчтэй холбогдолтой хавтаст хэрэгтэй танилцъя гэхэд л нэг удаад 20000 төгрөг төлөх шаардлагатай болж байгааг нь эдийн засгийн соёлтой хориг гэхээс өөр аргагүй байна.

5. Төрийн нууцын тухай хууль нь хэтэрхий өргөн хүрээг хамарснаас аливаа төрийн байгууллагын бодлого үйл ажиллагаагаа сурталчилсан үйлдэл нь хууль зөрчсөн үйлдэл болох тохиолдол ч анзаарагдаж байна. Тухайлбал Монгол улсын гадаад бодлогын үзэл баримтлал нь хуулиар бол байнгын нууцын зэрэглэлтэй. Гэтэл ГХЯ-аас эрхлэн гаргасан "Цэнхэр номонд" энэхүү үзэл баримтлал нь хэвлэгдсэн байх бөгөөд уншаад үзэхэд даяаршлын эринд ийнхүү нээлттэй сурталчилах нь зөв зүйтэй гэж дэмжих сэтгэл төрөх жишээтэй.

6. Элдэв янзын зөвшөөрөл шаардах, хоног хугацаа заах, харилцан бие биерүүгээ түлхэж эзэнгүйдүүлэх, ямар нэгэн байгууллагын албан бичиг шаардах, их хэмжээний төлбөр шаардах, олон шат дамжлага дамжуулах зэрэг нь иргэд хүссэн мэдээллээ олж авахад нь хүндрэл саад болж байна.

Эцэст нь дүгнэж хэлэхэд төр нууцтай байх ёстой нь үнэн. Төрийн нууцыг хуулиар хамгаалах нь ч зөв. Гэхдээ төрийн нууц гэдэг иргэдээс аливаа мэдээллийг нуух, төрийн түшмэд иргэдэд тэгш, шудрага, нээлттэй үйлчлэх явдлаас татгалзах арга хэрэгсэл нь болох ёсгүй.

Бид өнөөдөр XXI-зуунд амьдарч байна. Ажилчин ангийн тоо; шинээр гарч байгаа янз бүрийн халдварт өвчний байдал, дэлгэрэлт; элдэв шалтгаанаар хорогдсон малын тоо, багш сурагчдын дунд буй ёс суртахуунгүй үйлдлүүд, гэмт хэрэг үйлдсэний улмаас хариуцлагад татагдсан нам, улсын байгууллагуудын хариуцлагатай ажилтаны тоо зэргийг нийтэлж нэвтэрүүлэхийг хориглож асан 1950-аад он түүх болон улирсан.

Гаалийн тариф, экспортын бараа бүтээгдэхүүний үнэ, гадаад худалдааны баланс, валютын нөөцөө чандлан нууцалж байсан 1960-аад он ч түүх болон одсон.

Гэвч бид мэдээллийг аль болох их нууцалбал сайн гэсэн гаж сэтгэхүйгээсээ салж хагацаж чадахгүй байна. Дэлхий ертөнц нэгдмэл болж, мэдээллийн технологийн хувьсгал гарч, "хавтгай дэлхийн" тухай онол хүчээ авч, африкийн ширэнгийн махчин омог хүртэл интернэтийн гайхамшгийг мэдэрч байхад Монголын төр, Төрийн нууцын тухай өнгөрсөн зууны ойлголтоосоо салж чадахгүй байгаа нь эмгэнэлтэй. Тэдний нууцалсан мэдээллийг гадаадын сайтууд чөлөөтэй дэлгэн тавьж, тэдний нууцалсан архивын материалыг үзэл суртлын хаалттай орон Хятадаас хүртэл судлаачид олж авч, тэдний тэнгэр тултал үнэ нэхсэн баримтыг интернэтээс үнэгүй, эсвэл үнэгүй шахам олж болж байна. Чөлөөт хэвлэл бол чөлөөт иргэд гэдгийг би ярианыхаа эхэнд зүгээр ч нэг ишлээгүй. Дэлхийн сэтгүүл зүйд цоо шинэ хандлага хүчээ авч эхэллээ. Мэргэжлийн сэтгүүлчидтэй зэрэгцэн "иргэн" сурвалжлагчид мэдээллийн ертөнц рүү хүч түрж эхэллээ. Тэд өөрсдийн мэдээллийн хүчирхэг сүлжээ байгуулан ардчиллын үнэт зүйлсийг хамгаалж эхэллээ. Иргэнд үйлчилж буй төр иргэнээсээ аль болох бага мэдээллийг нууцлах ёстой, иргэддээ нээлттэй төр илүү ардчилалтай гэдгийг бүгд

ойлгож, дэлхий даяар энэхүү иргэн-сурвалжлагчдад хүндэтгэл үзүүлж байна.

Харин Монгол улсад, ардчиллын замаар замнаад 16 жилийн нүүр үзэж буй оронд мэдээлэл авах гэсэн иргэдийн өмнө төрийн нууц хэмээх төмөр хаалт ил, далд хэлбэрээр хориг тээг болсоор байна. Төрийн нууц ба бодит байдлын дүр зураг гэвэл ийм л байна.